



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Чойбалсан

Г

Зорилтот жилийг батлах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг орон нутгийн бодлого шийдвэр болон аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд төр, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжээс дэвшүүлсэн зорилтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан зорилтот жилийн хэрэгжилтийг бүрэн хангаж, олон нийтэд таниулан мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, холбогдох байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хагас жил тутамд Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Д.Дамдинцоо)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ

Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дугаар сарын 03-ны өдрийн
А/01 дугаар захирамжийн хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, СУМ, АГЕНТЛАГ,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС
2025 ОНД ДЭВШҮҮЛСЭН “ЗОРИЛТОТ ЖИЛ”-ИЙН НЭРШИЛ

№	Газар, хэлтэс, сумын нэрс	Зорилтот жилийн нэршил
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	Амьдрах орчныг сайжруулах жил
	Сумын нэр	Зорилтот жилийн нэршил
1	Баяндун	Бүтээн байгуулалтын жил
2	Баянтүмэн	Эко сум
3	Баян-Уул	Дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил
4	Булган	Эрүүл, аюулгүй орчныг сайжруулах жил
5	Гурванзагал	Ундны усны эрүүл ахуйн жил
6	Дашбалбар	Цахим хөгжил
7	Матад	Төрийн үйлчилгээний чанар-Бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх жил
8	Сэргэлэн	Цахим мэдээллийн ил тод байдлыг хангах жил
9	Халхгол	Төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих жил
10	Хөлөнбуйр	Хувь хүний хөгжил-Өрхийн үйлдвэрлэл, бүтээн байгуулалт-Эко сум
11	Хэрлэн	Тохижилт, үйлчилгээ, хариуцлагын жил
12	Цагаан-Овоо	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих жил
13	Чойбалсан	Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил
14	Чулуунхороот	Бүтээн байгуулалтыг дэмжих жил
	Газар, хэлтэс, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага	Зорилтот жилийн нэршил
1	Байгаль орчны газар	Хөрсний доройтол, бохирдлыг бууруулах жил
2	Биеийн тамир, спортын газар	Спортын холбоодыг дэмжих жил
3	Боловсролын газар	Ёс зүй-Манлайлал
4	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Салбарын хяналтыг сайжруулах жил
5	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх жил
6	Мал эмнэлгийн газар	Ажиллах орчныг сайжруулж, хамтын ажиллагааг бэхжүүлэх жил
7	Нийгмийн даатгалын газар	Тогтвортой хөгжлийг дэмжих жил
8	Бүсийн төв, Онцгой байдлын газар	Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил
9	Орон нутгийн өмчийн газар	Өмчийн эзэмшил, ашиглалт, захиран зарцуулалтын хяналтыг эрчимжүүлэх жил

10	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Чадварлаг, Бүтээмжтэй, Хариуцлагатай, Ёс зүйтэй, Зөв хандлагыг эрхэмлэх жил
11	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эрчимжүүлэх жил
12	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Хүнсний аюулгүй байдлыг хангах жил
13	Статистикийн хэлтэс	Статистикийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх жил
14	Татварын газар	Зөвлөн туслагч Татварын алба
15	Улсын бүртгэлийн хэлтэс	Хүний эрхийг дээдэлсэн, шударга ёсны зарчмыг эрхэмлэсэн жил
16	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	Мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх жил
17	Худалдан авах ажиллагааны газар	Ёс зүйг дээдлэх жил
18	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Эрүүл аюулгүй ажлын байр-Зохистой хөдөлмөр эрхлэлт
19	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг чадавхжуулах жил
20	Цагдаагийн газар	Цахим технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, шуурхай байдлыг ханган, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
21	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Хүний хөгжил, цахимжуулалт, үйлдвэржилтийг дэмжих жил
22	Бүсийн шүүх шинжилгээний төв	Чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлж, хэргийн газрын үзлэг, шинжилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх жил
23	Эрүүл мэндийн газар	Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил
24	Хөгжимт драмын театр	Шилдэг уран бүтээлийг сурталчлах жил
25	Аймгийн Музей	Байгууллагын тохижилт, эрүүл аюулгүй орчныг сайжруулах жил
26	Аймгийн төв Номын сан	Үндэсний бичиг үсэг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих жил
27	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх жил
28	“Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ	Иргэн төвтэй байгаль хамгааллыг дэмжих жил
29	“Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх төв” ОНӨААТҮГ	Хамтын ажиллагааг өргөжүүлэх жил
30	“Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв” ОНӨААТҮГ	Бичил бизнесийг дэмжих жил
31	“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ	Эрүүл, аюулгүй, цэвэр орчинг бүрдүүлэх жил